

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (√) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 6.3-т “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэх журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах захиргааны гэрээний загвар, бүртгэл, тайлангийн маягтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан. Энэхүү заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/14 дүгээр тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдөр бүртгүүлэв.			√	
2.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд энэ оны 01 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, зарим хуулийн этгээдийн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлж, чөлөөлөх, мөн ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх тухай зохицуулалтыг шинээр тусгасан. Хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хуулийн 32.8-д заасан “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар холбогдох яамдын саналыг авсан.			√	
3.	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх хэрэгцээ шаардлагын тандан судалгааг 2023.02.15-ны өдөр ОУХБ, МҮЭХ, МАОЭНХ болон холбогдох төрийн болон ТББ-ын төлөөлөлд танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэхүү хууль шинэчлэгдсэнээр гадаад орны үйлдвэрчний эвлэлийн байгууллагын туршлагыг судалж, Үйлдвэрчний Эвлэлийн үйл ажиллагааг орчин үеийн жишигт нийцүүлэн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох нөхцөл бүрдэх юм.			√	
4.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, аймаг нийслэл, салбарын ҮЭ-ийн холбооны гишүүдээр 2 дугаар сарын 7-ны өдөр, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудаар 2 дугаар сарын 10-ны өдөр тус тус хэлэлцүүлсэн.		√		
5.	Нийгмийн бодлогын байнгын хорооны зөвлөхүүдэд Нийгмийн даатгалын багц 5 хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх, уулзалтыг 4 удаа хамтран зохион байгуулав.		√		
6.	Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн хүрээнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөлтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэгт холбогдох газрын дарга, мэргэжилтэн оролцов.			√	
7.	Төрийн ордонд 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Залуусын төлөөлөл, сайн дурын даатгуулагч, малчдад Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх санал авах уулзалтад тус яамны холбогдох газрын дарга, ахлах мэргэжилтэн оролцов.			√	
8.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал дараахь мэдээлэл, танилцуулга хийв. Үүнд:			√	

	<ul style="list-style-type: none"> ✓ Ийгл ТВ-ээс зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн хэлэлцүүлэгт 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр оролцов. ✓ Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Даатгалын бодлогын зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуралд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал танилцуулав. ✓ “Өнөөдрийн сонин”-ы 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн дугаарт Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар тайлбар мэдээлэл өгөв. 				
9.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийж, тус хуулийн хэрэгцээг тодорхойлж, холбогдох стандарт болон эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах зорилгоор “Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ”, “Үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа”-г хийж, явцыг мэргэжлийн байгууллагуудад тайлагнаж, хэлэлцүүлэв.			√	
10.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэнээс Сангийн сайдын 2023 оны 01/514 тоот албан бичгээр зөвшөөрсөн хариу ирүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01/800 дугаар албан бичгээр ирсэн саналыг хуулийн төслийн шинэчилсэн найруулгад тусган, зөвшөөрөл авахаар дахин хүргүүлсэн.		√		
11.	“Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зураглал, Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартын олон улсын туршлага”, “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандартын төслийн танилцуулга” “Хүүхдийн хөгжил, хүүхдийн хөгжих эрхийн талаарх олон улсын хандлага”, “Хүүхдийн хөгжлийн талаарх Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/69 дүгээр тушаалаар байгуулсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо”-ны гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, судлаачдыг хамруулав.			√	
12.	“Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг хангах, чадавхижуулах чиглэлээр гаргасан ололт амжилт, тулгарсан бэрхшээл” сэдэвт НҮБ-ын UNW/2022/007 тоот тогтоолын хэрэгжилтийн тайланг боловсруулан, орчуулж байна.			√	
13.	АНУ-ын Нью-Йорк хотноо энэ оны 3 дугаар сарын 6-17-ны өдрүүдэд зохион байгуулагдах НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 67 дугаар чуулганы үндсэн илтгэлийг боловсруулж байна.				√
14.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, харьяа салбар зөвлөлд хүргүүлээ.			√	
15.	-Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг боловсруулж байна. -Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх, үйл ажиллагааг тогтмолжуулж, салбарын гишүүдийг чадавхижуулах ажлыг зохион байгуулж байна. -Нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар судалж байна.			√	
16.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.19, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалтын нийтлэг журам”-ыг үндэслэн “Баримт бичгийн нэгдсэн дугаар олгох тухай” зааврыг шинээр боловсруулан санал авч, батлуулахаар ажиллаж байна.			√	
17.	“Хяналт шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам”-ын төсөл боловсруулж хавсралтаар салбарын хяналт шалгалтанд ашиглах хяналтын хуудасны загварын төслийг тус тус боловсруулан батлуулахаар ажиллаж байна. 1. Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр: 4.1.2 кодтой Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас, 4.6 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас 2. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр: 4.1.1 кодтой Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас, 3. Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр: 4.2 кодтой Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас, 4.3 кодтой Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.4 кодтой Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолтыг шалгах хяналтын хуудас,			√	

	4.5 кодтой Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.7 кодтой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас				
II	Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр				
18.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г хэлэлцүүлж батлууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16 дугаар тушаалаар батлууллаа.			√	
19.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг сонсох, 2023 оны төсвийн хуваарь”-ийг батлууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны төсвийн хуваарийн тооцоо судалгааг хийж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/15 дугаар тушаалаар батлууллаа.			√	
20.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолоор 20 “Ажил мэргэжлийн стандарт”-ыг батлуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д “Ажил мэргэжлийн стандартаар хөдөлмөрийн нөхцөл, ажилтын ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно” гэж заасан. Энэ хүрээнд Монголын Ажил олгогчдын эздийн холбоо, Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэнтэй хамтран 20 стандартыг боловсруулж батлууллаа.			√	
21.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор “Эрэлтэд нийцсэн ур чадвар”-ын хөтөлбөрийг батлуулсан. Тус хөтөлбөр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тус хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй, мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар болон мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах замаар ажилтай, орлоготой болгох, ажлын байраар хангах зорилготой.			√	
22.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэн бүрт төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд ашиглалтад оруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалын дагуу холбогдох ажлыг хийж, “Ejob” платформын үйл явцын талаарх тайлан мэдээг 10 хоног тутам авч нэгтгэн үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулж байна. 2023 оны 02 дугаар сарын байдлаар “Ejob” платформд Бүртгэлтэй ажлын байрны тоо-3412, Ажил хайгчийн тоо-9173, Ажил олгогчийн тоо-3545, Ажилд зуучлагдсан иргэдийн тоо-435 болсон байна.			√	
23.	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын танилцуулга зэрэг холбогдох мэдээллийг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөгжлийн төлөвлөгөө			√	

	боловсруулах аргачлал"-ын дагуу бэлтгэн Эдийн засаг, хөгжлийн яаманд цахимаар хүргүүлээд байна.				
24.	Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийх мэдээллийн жагсаалтад тусгах саналыг 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02/440 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.			√	
25.	Дэлхийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны цаашдын хамтын ажиллагааны уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Дэлхийн банкны зүгээс бичил зээл, техник туслалцаа зэрэг олон хувилбараар тэргүүлэх чиглэлүүдэд хамтран ажиллах боломжтой талаар танилцуулж 2023 оны 03 дугаар сард дахин уулзалт товлосон.			√	
26.	Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журамд нэмэлт оруулж байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хагас, бүтэн өнчин хүүхдүүдийг амьжиргааны түвшинг харгалзахгүй 91 хувьд багтаан хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулах зорилгоор "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Тогтоолын төслийг Засгийн газрын гишүүдээс санал авахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 2/477 дугаар албан бичгээр хүргүүлэв.			√	
27.	Хүний эрхийн үндэсний комиссоос хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой 4 чиглэлээр баримт, тайлбар мэдээлэл хүссэн албан бичгийн хариуг боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2023 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 2/320 дугаар албан бичгээр хүргүүлэв.			√	
28.	2023 оны 2 дугаар сарын хүүхдийн мөнгөний олголттой холбоотой Иргэдээс гарах нийтлэг асуултын хариултаар болон хэвлэлийн мэдээний агуулгыг бэлтгэн аентлаг, аймаг, дүүргийн халамжийн газар, хэлтэс, дуудлагын төвд нээлттэй утсанд хариу өгч ажиллах ажилтануудад хүргүүлэв.			√	
29.	E-mongolia, ehalamj системээр "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ" цэсэнд хүсэлт авах 4 төрлийн талбарын агуулга, тайлбар бэлтгэв.	√			
30.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн захирамжаар байгуулагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцыг дүгнэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, хэрэгжүүлэлтийн явын талаар олон нийтэд таниулах үүрэг бүхий ажлын хэсэгт ХНХ-ын дэд сайд С.Зулпхар ажиллаж, БТГ-ын холбогдох ахлах шинжээч, ахлах мэргэжилтэн Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгыг хариуцан холбогдох яамдтай хамтран ажиллаж, мэдээлэл бэлтгэж байна.			√	
31.	УИХ-ын гишүүдэд зориулж Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын зорилтуудын биелэлтээр "Ярианы сэдэв" бэлтгэн дарга, удирдлагад танилцуулан гишүүдэд хүргүүлэв. Түүнчлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотойгоор хүүхдийн мөнгөнд хамрагдах өрхийг тодорхойлох аргачлал, түүнийг тойрсон шүүмжлэлтэй асуудлууд мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн олголтын талаар мэдээлэл нэмж бэлтгэж өгсөн.			√	
32.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, хүнсний эрхийн бичиг зэрэг мөнгөн дүнг нэмэгдүүлэх шаардлагатай нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг 2023 онд нэмж шаардагдах 87.1 тэрбум төгрөгийн хөрөнгийн тооцоог гарган сайд, удирдлагад танилцуулав.			√	
33.	L4051/52-MON: "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төслийн хэрэгжилтэд дунд хугацааны үнэлгээ хийх багийнхан болон АХБ-ны Зүүн Азийн Бүсийн газрын нийгмийн хамгааллын Тэргүүлэх мэргэжилтэн, Төслийн багийн ахлагч Карин Шельчихтай хийх уулзалт мэдээлэл бэлтгэж ажиллалаа.			√	
34.	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр олон улсад амжилттай хэрэгжиж байгаа "Төгсөлтийн аргачлал" хөтөлбөрийн хүрээнд анхан шатанд гар бие оролцож ажиллаж буй коуч болон халамжийн мэргэжилтнүүдийн уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж цаашид анхаарч ажиллах санал, зөвлөмжүүдийг өгөв.			√	
35.	2023 оны 2 дугаар сарын хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой постер болон зурагт хуудасны мэдээллийг боловсруулав.			√	
36.	Өрхийн мэдээллийн санд тулгуурлан хүүхдийн мөнгө олгох, бүх өрхийн мэдээллийг шинэчлэх ажилтай холбогдуулан дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэв: Үүнд:				

	<p>a. иХаламж, иМонголиа системээр дамжуулан хүүхдийн мөнгөнд хамрагдах эсэхийг шалгах үйлчилгээний ажлын даалгавар гаргах болон үйлчилгээг тестлэх, нэвтрүүлэх ажлыг хийж иМонголиа академи УТҮГ болон ХХҮЕГ-ын Мэдээллийн технологийн төвтэй хамтран гүйцэтгэв. Хүүхдийн мөнгө авах үйлчилгээг дараах үе шаттай байхаар ажлын даалгаварыг боловсруулсан болно.</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн мөнгөнд хамрагдах эсэхийг шалгах • Өрхийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай хүсэлт • Төрийн байгууллага дахь мэдээлэл шинэчлэх хүсэлт • Өрхийн амьжиргааг дахин үнэлүүлэх хүсэлт • Хүүхдийн мөнгөн тэтгэмж авах үйлчилгээнээс татгалзах хүсэлт <p>b. Өрхийн мэдээллийн сангийн программ хангамжийг тестлэх, зарим шаардлагтай өөрчлөлт хийх ажилд дэмжлэг үзүүлэв.</p> <p>c. Хүүхдийн мөнгөтэй холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдолын дагуу иргэдийн мэдээллийг шалгаж өгөх, зөвөлгөө өгөх зэрэгээр мэдээлэл өгч ажиллав.</p> <p>Хүүхдийн мөнгө олгох үйл ажиллагаатай холбоотой танилцуулгыг бэлтгэн удирдлагуудад танилцуулав.</p>				√
37.	“ЕJOB” платформыг хөгжүүлэлт бүрэн хийгдэж дуусаагүйтэй холбогдуулан ҮСХ-тэй холбогдож албан бичгийг хүргүүлсэн.				√
38.	Цахим бүртгэлийн системийн шинэчлэлтэй холбогдуулан АХА улирлын мэдээний маягтыг шинэчлэн батлуулах талаар ХХҮЕГ-тай холбогдож, зохих мэдээллийг аван нэгтгэж байна.				√
39.	Орон нутаг руу шилжин ажиллах албан хаагчдын цалингийн нэмэгдэл постер, Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл постер, Төрийн тусгай албан хаагчдын цалингийн нэмэгдэл постер, Дундаж тэтгэвэр, бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ постер, Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр авагчдын тоо, тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө постер, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй болсон хороод нийслэлээр постер, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй болсон сум хороод аймгаар постер, Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж байна постер, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогддог жижиг зээлийн хүүгийн хэмжээ буурлаа постер тус тус бэлтгэлээ.				√
40.	<ul style="list-style-type: none"> ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа явуулж буй 3 төвийн үйл ажиллагаатай танилцав. ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын ахмадын холбоотой 2023 онд хамтран ажиллах хүрээнд “Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ”-г 2023 оны 02 дугаар сарын 1-ний өдөр батлав. ✓ ЮНЕСКО байгууллагаас 2023 онд УБ хотын хэмжээнд хүртээмжийн үнэлгээний ажил зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ хүрээнд суурь судалгааны асуулга боловсруулахад хамтран ажиллав. 				√
41.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам”-ын дагуу хүүхэд харах үйлчилгээнд 1696 хүүхэд хамрагдсан. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчидтэй 2 удаагийн уулзалт зохион байгуулж санхүүжилт, хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хяналт шалгалтын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажилласан.				√
42.	Хорт хавдартай хүүхдийн нийгмийн хамгаалал, эрх зүйн орчны шинжилгээ хийх ажлыг НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр эхлүүлж, хорт хавдартай хүүхдийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээний тайланг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлсэн. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч болон ЭМЯ-ны холбогдох албан тушаалтны хамтаар ЭХЭМҮТ-д ажиллаж, хорт хавдартай хүүхдийн нөхцөл байдал, хүүхдийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг эхлүүлэхээр болсон.				√
43.	“Сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэнд” үндэсний судалгааны ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, туршилтын судалгааг нийслэлийн ерөнхий боловсролын 2 сургууль, Төв аймгийн Баянчандмань сумын 1 сургуульд зохион байгуулж байна.				√
44.	Дархан-Уул аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн дэргэд цахим мэдээлэл, үйлчилгээ, сургалтын “Юнител Хаб” цэгийг туршилтаар байгуулсантай холбогдуулан асуудал, шийдлийг хэлэлцэх, аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн дэргэд тус цэгийг байгуулахад цаашдын				√

	хамтын ажиллагаа, талуудын оролцоог хэлэлцэх, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд Санамж бичгийг байгуулах тухайд санал солилцох уулзалтыг НҮБХАС, ГБХЗХГ, "Юнител" ХХК-ий төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. ХНХЯ болон "Юнител" группийн Хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг боловсруулаад байна.				
45.	Монгол Улсын Ерөнхий Сайдын 99 дүгээр захирамжаар баталсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зэрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)"-ний хэрэгжилтийн тайланг боловсруулж, үнэлгээ хийлгэж, ЖҮХ-нд хүргүүллээ.			√	
46.	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулж, 2023 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналын хамт МУГХУСА33АА-нд хүргүүллээ.			√	
47.	Хамтарсан багийн гишүүдэд зориулсан 12 багц сургалтын гарын авлагад засвар хийж, саналыг тусгуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлэв.			√	
48.	-Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны судалгааг гаргаж, Нийслэлийн Прокурорын газарт албан бичгээр хүргүүлсэн. -Зөрчлийн хэргийн харьяалалаар Хөдөлмөрийн хяналтын эрх бүхий албан тушаалтнаас Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлд заасан зөрчилд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах талаар бүрэн тусгагдаагүй байсантай холбогдуулан Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаар харьцуулсан судалгаа гаргасан.			√	
49.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 ¹ .1."Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага эрсдэлийн үнэлгээг харгалзан дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор салбарын хяналтад байх объектуудад 12 дахь жилдээ эрсдэлийн үнэлгээ хийлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр 2023 онд хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах 3 шалгуур үзүүлэлтээр 24076 аж ахуйн нэгж, байгууллагын, хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 26139 объектод эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлж ажиллалаа. Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан нийт объектын 50.1% нь хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр, 27.6% нь нийгмийн хамгааллын хяналт, 22.1% нь хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр тус тус үнэлэгдсэн байна.			√	
	<p style="text-align: center;">Салбарын эрсдэлийн үнэлгээ- үр дүн</p> <p style="text-align: center;">2023 оны ээлжит эрсдэлийн үнэлгээгээр /хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналт/-ын чиглэлээр нийт 26139 иргэн аж ахуй нэгжид эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.</p>				
50.	Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Инженерийн шийдэлтэй иргэний барилгын дотоод орчны бохирдлын хяналтын MNS GB 50325:2023 стандартын төсөлд санал хүргүүлэв.			√	
51.	Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг салбар яамдад шилжүүлсэний дагуу Яамдын салбарын хяналтын газруудаас зохион байгуулсан "Төрийн хяналт шалгалтын тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ"			√	

	сэдэвт Прокурорын байгууллагатай хамтарсан сургалтад оролцож, Хөдөлмөрийн хяналтын талаар тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.				
52.	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/24 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг Нийгмийн хамгааллын хяналтын чиг үүргийн талаар санал, дүгнэлт боловсруулж удирдлагуудад танилцуулав.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
53.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1,2,3,4 дүгээр улирал, 2023 оны 01 дүгээр сарын байдлаар гаргаж, www.mlsr.mn сайтад байршуулсан.			√	
54.	Хугацаат цэргийн албан хаагчдад мэргэжил олгох талаар санал зөвлөмж боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд болон бусад удирдлагуудад танилцуулсан.			√	
55.	“Каритас чех репаблик” төрийн бус байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээний талаар мэдээллийг бэлтгэн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн.			√	
56.	Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлсөнөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг хэлэлцүүлж шинэчлэн батлуулав.		√		
57.	“Итгэлцүүр батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар Үндэсний статистикийн хороонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны 2 дугаар сарын 14-ны 02/422 дугаартай албан бичгийг хүргүүлэв.			√	
58.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Хяналт, шалгалт хийх тухай” А/11 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу ХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрүүдэд холбогдох шалгалтыг зохион байгуулав.			√	
59.	“Ганц бие ахмад настны тэтгэврийн зарцуулалт, хуртээмжийн судлагаа”-г Европын Холбооны SoiciEUX байгууллагатай хамтран хийх төслийн хүрээнд Европын холбоо, Олон Улсын зөвлөхүүд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын төлөөлөлтэй уулзалт хэлэлцүүлгийг 2023 оны 2 дугаар сарын 9-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр зохион байгуулж, уулзалтад Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, ахлах мэргэжилтэн оролцов.			√	
60.	УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны “Чиглэл өгөх тухай” 2022 оны 14 дүгээр тогтоолоор Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлийг Засгийн газарт өгсөн. Уг тогтоолд тусгагдсан салбарын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээний холбогдох биелэлтийг гаргаж 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01/375 тоот албан бичгээр Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлсэн.	√			
61.	2023 оны 02 дугаар сарын 08-ны дотор зөрүүтэй мэдээллээ засуулсан нийт хүүхэдтэй өрхийг 2023 оны 02 дугаар сарын 16-нд өрхийн амьжиргааг үнэлж 2 дугаар сарын хүүхдийн мөнгийг олгосон. Үүнтэй холбоотойгоор 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Дэд сайдаар ахлуулж НХБХЗГ, БТГ, ХХҮЕГ оролцсон хурал болж Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох явцын талаар мэдээлэл сонсож, тулгамдаж байгаа асуудлын талаар санал солилцов.			√	
62.	2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Үндэсний статистикийн хорооны төлөөлөлтэй ХХҮЕГ-т ажиллаж Хүүхдийн мөнгөн тэтгэмж бодох аргачлалыг иргэдээс буруу бодож байна гэж гомдол гаргасны дагуу шалгаж кейс дээр ажиллав.			√	
63.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн 5 дугаар тайланг хэлэлцүүлсэн тухай ЗГ-ын хуралд танилцуулах холбогдох материалыг бэлтгэн ГХЯ, ЗГХЭГ-т хүргүүлэв.		√		
64.	<ul style="list-style-type: none"> ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг сургуульд элсүүлэх үйл ажиллагаанд хийсэн “Элсэлт-2022” мониторингийн үр дүнг танилцуулах, хэлэлцүүлэгт оролцож, ХБХ-ийг сургуульд элсүүлэх чиглэлээр цаашид хамтран ажиллах санал солилцов. ✓ ЮНЕСКО байгууллагаас 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих болон конвенцын тайлан боловсруулах ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн тайлан боловсруулах албан хаагчдыг чадавхижуулах сургалт, хэлэлцүүлэг, 			√	

	<p>конвенцийн зүйл заалтыг дотоодын хууль тогтоомжтой нийцсэн эсэх чиглэлээр судалгаа хийх зөвлөх үйлчилгээний 2 ажилд тус байгууллагаас дэмжлэг дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Бээжингийн төлөөлөгчийн газарт уг хоёр ажлыг хэрэгжүүлэх төсөл боловсруулж, ЮНЕСКО-ын Монголын Үндэсний Комисст хүргүүлэв.</p> <p>✓ АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн С3 багцын хүрээнд боловсруулагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээний тайланг боловсруулж, хүргүүлэв.</p> <p>✓ ХБ-тэй хүүхдэд цогц дэмжлэгийн үйлчилгээг хөгжлийн төвөөр дамжуулан үзүүлэх нь сэдэвт хэлэлцүүлгийг “Эрхэм нандин сувд” ТББ-тай хамтран зохион байгуулав.</p>				
65.	Хэмжилт, туршилтын төвийн хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, шинжилгээнд ашиглагдаж байсан багаж, хэмжих хэрэгслүүд болон Хамгаалах хэрэгслийн лабораторийн суурин тоног төхөөрөмжүүдийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвд шилжүүлж өгсөн.			√	
66.	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай” 3 дугаар зүйлийн 3.4-дэх заалт “эрсдэлийн түвшний үнэлгээгээр их эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөнө” гэж заасны дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөлд 3 хяналтын чиглэлээр аймаг, нийслэлийн 19140 объектыг (их эрсдэлтэй 6546, дунд эрсдэлтэй 12594) тус тус сонгосон. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр их эрсдэлтэй 908 объект, дунд эрсдэлтэй 722 объект; • Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр их эрсдэлтэй 328 объект, дунд эрсдэлтэй 178 объект; • Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр их эрсдэлтэй 436 объект, дунд эрсдэлтэй 358 объект тус тус хяналт шалгалтад хамруулахаар сонгосон байна. <p>Салбарын хяналтын чиглэлээр 2023 оны эрсдэлийн үнэлгээг хийх явцад цахим системтэй холбоотой үүсэж буй 43 алдаа, мөн улсын байцаагчдын шилжилт хөдөлгөөн их хийгдсэн учраас системд нэвтрэх эрх, хөдөлгөөн зохион байгуулалттай холбоотой 46, эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөмжийг 3, нийт 92 удаагийн алдаа засах, зохион байгуулалтын ажлыг хийж ажиллалаа.</p>			√	